



03/2021

Тархаасан: 2021 оны 04 дугаар сарын 12

АНУ-ын эдийн засаг 

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны мэдээллээр тус улсын ДНБ-ий жилийн өсөлт 2020 оны 4 дүгээр улиралд 4.3 хувь байна.

Хэрэглээний үнийн индекс улирлын нөлөөллийг арилгаснаар 2021 оны 2 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

АНУ-ын экспорт 2021 оны 2 дугаар сард 187.3 тэрбум ам.доллар, импорт 258.3 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 71.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх сараас экспорт 5.0 тэрбум ам.доллар, импорт 1.7 тэрбум ам.доллороор тус тус буурч, алдагдал 3.3 тэрбум ам.доллороор өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс урьдчилсан гүйцэтгэлээр 2021 оны 2 дугаар сард 104.7 (2012=100) болж, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар, өмнөх сараас 2.2 хувиар буурсан байна.

Ажилгүй иргэдийн тоо улирлын нөлөөллийг арилгаснаар 2021 оны 3 дугаар сард 9.7 сая, ажилгүйдлийн түвшин 6.0 хувь болж, өмнөх сараас ажилгүй иргэдийн тоо 262.0 мянгаар, ажилгүйдлийн түвшин 0.2 пунктээр буурсан байна.

БНХАУ-ын эдийн засаг 

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны мэдээллээр тус улсын ДНБ 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өссөн бол 2020 оны ДНБ-ий жилийн өсөлт 2.3 хувь болсон байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн бол өмнөх сараас 0.5 хувиар буурсан байна.

БНХАУ-ын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 2 сард 834.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 41.2 хувиар өссөн байна. Үүнд экспорт 468.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 60.6 хувиар, импорт 365.6 тэрбум ам.долларт хүрч, 22.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний 2 сард 103.3 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2021 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар, өмнөх сараас 1.6 хувиар өссөн байна.

Хотын хүн амын ажилгүйдлийн түвшин 2021 оны 2 дугаар сард 5.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр буурч, өмнөх сараас 0.1 пунктээр өссөн байна.



Япон улсын ДНБ 2020 оны 4 дүгээр улиралд урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх улирлаас 2.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар тус тус өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 2 дугаар сард 101.6 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурч, өмнөх сараас (улирлын нөлөөллийг арилгаснаар) 0.1 хувиар өссөн байна.

Экспорт 2021 оны 2 дугаар сард 6.0 их наяд иен, импорт 5.8 их наяд иен болж, өмнөх оны мөн үеэс экспорт 4.5 хувиар буурч, импорт 11.8 хувиар өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны 2 дугаар сард 215.9 тэрбум иений ашигтай гарсан байна.

Улирлын нөлөөллийг арилгасан аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2021 оны 2 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 95.7 (2015=100) болж, өмнөх сараас 2.1 хувиар буурсан байна.

Япон улсын ажилгүй иргэдийн тоо 2021 оны 2 дугаар сард 2 сая хүн болж, өмнөх оны мөн үеэс 370 мянган хүнээр нэмэгдсэн байна. Улирлын нөлөөллийг арилгасан, ажилгүйдлийн түвшин 2.9 хувь байна.



Европын холбооны Статистикийн газрын мэдээллээр тус холбооны гишүүн улс, орнуудын улирлын нөлөөллийг арилгасан ДНБ 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.5 хувиар буурсан байна.

Европын Холбооны гишүүн орнуудын инфляцын жилийн түвшин 2021 оны 2 дугаар сард 1.3 хувь болж, өмнөх сараас 0.1 пунктээр өсөж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

Европын Холбооны гишүүн орнуудын экспорт 2021 оны 1 дүгээр сард 148.3 тэрбум евро болж, өмнөх оны мөн үеэс 10.8 хувь, импорт 139.9 тэрбум евро болж 16.9 хувиар тус тус буурсан байна. Гадаад худалдааны тэнцэл 8.4 тэрбум еврогийн ашигтай гарсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2021 оны 2 дугаар сард 106.5 болж, өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна.

Европын Холбооны гишүүн орнуудын ажилгүйдлийн түвшин улирлын нөлөөллийг арилгаснаар 2021 оны 2 дугаар сард 7.5 хувь болж, өмнөх сарын түвшинд байгаа бол өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 34 мянгаар, өмнөх оны мөн үеэс 1.9 саяар өсжээ.



ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоогоор тус улсын ДНБ 2020 онд өмнөх оноос 3.0 хувиар буурсан байна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өмнөх оны эцсээс 2.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн байна.

ОХУ-ын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны 1 дүгээр сард 43.8 тэрбум ам.долларт болж, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар буурсан байна. Дээрх бууралтад экспорт 26.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. Харин импорт 17.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өсжээ. Гадаад худалдааны тэнцэл 2021 оны 1 дүгээр сард 8.9 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.


Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2021 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өмнөх сараас 1.4 хувиар буурсан байна.

Ажилгүй иргэдийн тоо 2021 оны 2 дугаар сард 4.2 саяд хүрч ажилгүйдлийн түвшин 5.7 хувь болсон байна.

Зэсийн үнэ

Лондоны үнэт металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2021 оны эхний гурван сарын дунджаар 8537.1 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2899.0 ам.доллараар өссөн байна.


Зураг 1. Лондоны үнэт металлын бирж дэх зэсийн үнэ, жил бүрийн эхний гурван сарын дунджаар



Алтны үнэ

Лондоны үнэт металлын биржид 1 унц алтны үнэ 2021 оны эхний гурван сарын дунджаар 1797.8 ам. доллар болж, өмнөх оны мөн үеэс 214.6 ам. доллароор өссөн байна.


Зураг 2. Лондоны үнэт металлын бирж дэх алтны үнэ, жил бүрийн эхний гурван сарын дунджаар



Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррель газрын тосны үнэ 2021 оны эхний гурван сарын дунджаар 57.9 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 11.9 америк доллароор өссөн байна.

Зураг 3. Нью-Йоркийн худалдааны бирж дэх газрын тосны үнэ, жил бүрийн эхний гурван сарын дунджаар



Хөрөнгийн биржийн индекс

АНУ-ын Хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2021 оны эхний гурван сарын дунджаар 31483.64 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 4793.16 нэгжээр өссөн байна байна.

Токиогийн Хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2021 оны эхний гурван сарын дунджаар 28987.72 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 7055.29 нэгжээр өссөн байна.

Лондоны Хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2021 оны эхний гурван сарын дунджаар 6665.23 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 659.19 нэгжээр буурсан байна.

Хүснэгт 1. Хөрөнгийн биржийн индекс, сараар

	Аж үйлдвэрийн Dow Jones	Nikkei-225 ²	FTSE-100 ³
2017 I	19908.15	19194.06	7211.36
II	20424.14	19188.73	7240.42
III	20823.06	19340.18	7359.53
2017 I-III	20385.12	19240.99	7270.44
IV	20684.69	18736.39	7263.60
V	20936.81	19726.76	7422.66
VI	21331.40	20045.40	7455.80
VII	21581.25	20038.68	7395.90
VIII	21890.77	19601.37	7409.17
IX	22173.41	19912.92	7334.65
X	23020.00	21262.50	7508.90
XI	23557.92	22525.80	7418.50
XII	24545.38	22769.90	7481.70

2018 I	25804.02	23712.21	7695.65
II	24981.55	21991.68	7255.90
III	24582.17	21395.51	7090.09
2018 I-III	25122.58	22366.47	7347.21
IV	24582.17	21868.79	7288.22
V	24572.53	22590.05	7690.22
VI	24790.11	22562.88	7656.94
VII	24978.23	22322.16	7651.06
VIII	25629.99	22494.14	7605.61
IX	26232.67	23159.29	7385.92
X	25609.34	22690.78	7137.04
XI	25258.68	21967.87	7040.81
XII	23832.11	21402.72	6790.90
2019 I	24157.80	20460.51	7558.00
II	25605.53	21123.64	7313.45
III	25722.62	21414.88	5741.89
2019 I-III	25161.98	20999.68	6871.11
IV	26401.58	21964.86	6871.11
V	25744.79	21218.38	6861.59
VI	26160.10	21060.21	7147.32
VII	27089.19	21593.68	7204.56
VIII	26057.73	20629.68	7434.20
IX	26900.21	21585.46	7275.27
X	26736.80	22197.47	7359.32
XI	27797.05	23278.09	7549.25
XII	28167.01	23660.38	7203.48
2020 I	28879.99	23642.92	7221.26
II	28519.73	23180.37	7348.34
III	22671.72	18974	7403.66
2020 I-III	26690.48	21932.43	7324.42
IV	23293.89	19208.36	5729.35
V	24271.02	20543.26	5956.30
VI	26074.14	22486.93	6244.63
VII	26260.58	22529.47	6167.36
VIII	27720.77	22901.45	6073.78
IX	23272.21	23306.95	5933.01
X	23604.85	23451.44	5851.49
XI	22044.80	25384.87	6222.53
XII	20477.00	26772.00	6518.87
2021 I	32345.64	28189.06	6698.52
II	31283.91	29458.80	6583.57
III	30,821.35	29315.30	6713.59
2021 I-III	31483.64	28987.72	6665.23

Мэдээлэл авах линкүүд:

1. <http://www.bea.gov/>
2. <http://www.stats.bls.gov>
3. <http://www.census.gov>
4. <http://www.federalreserve.gov>
5. <http://www.bls.gov>
6. <http://www.stats.gov.cn>
7. <https://www.esri.cao.go.jp>

8. <http://www.stat.go.jp>
9. <https://www.customs.go.jp>
10. <https://www.meti.go.jp>
11. <https://ec.europa.eu/eurostat>
12. <https://www.economy.gov.ru>
13. <https://rosstat.gov.ru>
14. <http://www.lme.com>
15. <http://www.lbma.org.uk/>
16. <http://www.finance.yahoo.com>

Тайлбар: *Улирлын нөлөөллийг тооцоогүй.

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны
газрын статистикч Б.Гэрэл
Утас : (976-51)-262903

